



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ



# Ганц бие ахмад настны тэтгэврийн зарцуулалт, хүртээмжийн судалгаа

Улаанбаатар хот  
2023 он



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



# Ганц бие ахмад настны<sup>1</sup> тэтгэврийн зарцуулалт, хүртээмжийн судалгаа

Улаанбаатар хот  
2023 он

<sup>1</sup>Ганц бие гэж ганц биеэр амьдарч буй 55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй хүнийг хэлнэ. Мөн энэ хүмүүс нь хүүхэдтэй байж болно.

Судалгааг гүйцэтгэсэн:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт,  
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нарны зам, 55-р байр 2 давхар 3  
тоот

Утас: (+976) 77121286

Вэб хуудас: [www.institute.gov.mn](http://www.institute.gov.mn)

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ.....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	6
ТАНИЛЦУУЛГА.....	7
Зорилго.....	9
Түүврийн зохиомж.....	9
СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	11
СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН.....	12
Тэтгэврийн хэмжээ ба дундаж орлого.....	12
Тэтгэврийн зарцуулалт.....	14
Тэтгэврийн хүрэлцээ.....	16
Ядуурах эрсдэл.....	18
Тэтгэврийн зээл.....	19
Агрегат орлуулах харьцаа.....	19
Орлогын тэгш бус байдал.....	20
Ахмадуудын санал, хүсэлт.....	23
ДҮГНЭЛТ.....	26
ЗӨВЛӨМЖ.....	28
ХАВСРАЛТ.....	29
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	32

## ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь “Ганц бие ахмад настны тэтгэврийн зарцуулалт, хүрэлцээний судалгаа”-г 2022-2023 онд Европын холбооны SOCIEUX+ Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн шинжээчдийн оролцоотойгоор хийж гүйцэтгэлээ. Ганц биеэр өрх үүсгэн амьдардаг ахмад настнуудын хувьд тэтгэврийн хүрэлцээг тусгайлан судалснаараа онцлог боллоо.

SOCIEUX+ нь Европын Холбооны улсууд үүсгэн байгуулсан, төр болон нийгмийн түншүүд хамтран санхүүжүүлдэг, техник хамтын ажиллагааны хүрээнд илүү сайн хөдөлмөр эрхлэх боломж, нийгмийн хамгааллын хүртээмжтэй тогтолцоог өргөжүүлэх, сайжруулах зорилготой байгууллага юм.

Судалгааны зорилго нь ганц биеэр өрх үүсгэн амьдардаг ахмад настнуудын тэтгэврийн зарцуулалт болон хүрэлцээг тодруулах бөгөөд ингэхдээ Европын холбооны тэтгэврийн хүрэлцээг хэмжих арга ашиглахыг зорьсон.


Энэхүү судалгаанд цахимаар болон өөрийн биеэр хүрэлцэн ирж аргачлал, асуулгын хуудас, түүвэр болон тайланд санал өгч, хамтран ажилласан Финланд Улсын доктор Хайки Гиламо (Heikki Hilamo), Португаль Улсын доктор Жорж Мигуэль Браво (Jorge Miguel Bravo), Бельги Улсын иргэн Стивен Яанссэн (Steven Janssen), Словак Улсын иргэн Славомир Дуришка (Slavomir Duriska) 4 зөвлөхүүд болон SOCIEUX+ Төслийн зөвлөх хатагтай Амандинь Моигнард (Amandine MOIGNARD) нарт гүн талархал илэрхийлье.

Мөн энэ судалгаанд утсаар ярилцлага өгч, санал бодлоо илэрхийлсэн 401 настан буурлууддаа чин сэтгэлийн угаас талархаж байгаагаа илэрхийлж, эрүүл энх, урт удаан наслахыг ерөөе.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлал, үр дүнтэй холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Б.БАТБААТАР

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ.....	9
Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан ахмад настнууд, хүйс, насны бүлгээр.....	11
Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан ахмад настнууд, байршил, насны бүлгээр...	11
Хүснэгт 4. Гэнэтийн зардалд бэлэн байдал, дундаж тэтгэврийн хэмжээгээр.....	16
Хүснэгт 5. Монгол Улсын хувьд тэтгэврийн хүрэлцээг тооцсон үр дүн.....	17


## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүний тоо, хүйсээр.....	7
Зураг 2. Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүний тоо, аймгаар.....	7
Зураг 3. Ахмад настны амьдарч буй сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр.....	11
Зураг 4. Судалгаанд хамрагдсан ганц бие ахмад настнуудын дундаж тэтгэврийн хэмжээ, боловсролын түвшингээр.....	12
Зураг 5. Ганц бие ахмад настны орлогын бүтэц, эзлэх хувиар.....	13
Зураг 6. Судалгаанд хамрагдсан ганц бие ахмад настны орлогын сэтгэл ханамж.....	13
Зураг 7. Тэтгэврийн орлогоор амьдрах боломж, дүнд эзлэх хувиар.....	14
Зураг 8. Үр хүүхэд болон ач зээдээ санхүүгийн тусламж үзүүлдэг хувь.....	15
Зураг 9. Тэтгэврийн орлогоор амьжиргаагаа залгуулахад хүрэлцэхгүй үед авсан хариу арга хэмжээ, эзлэх хувиар.....	15
Зураг 10. Сүүлийн нэг жилд хэрэглээний төлбөрөө төлж чадахгүй байх тохиолдол гарсан эсэх, хариултын эзлэх хувь, байршлаар.....	16
Зураг 11. Ядуурах эрсдэлийн түвшин, насны бүлэг, байршлаар.....	18
Зураг 12. Ядуурах эрсдэлийн түвшин, сууцны төрөлөөр.....	18
Зураг 13. Ядуурах эрсдэлийн түвшин, тэтгэврийн зээл авсан аваагүй ахмадуудаар.....	19
Зураг 14. Агрегат орлуулах харьцаа, дундаж болон медиан цалингаар.....	20
Зураг 15. Орлогын тэгш бус байдал, насны бүлэг, хүйсээр.....	21
Зураг 16. Материаллаг болон нийгмийн ноцтой гачигдал, хүйс, насны бүлгээр..	22
Зураг 17. Сүүлийн нэг жилд санхүүгийн хүндрэлийн улмаас худалдаж авч чадаагүй/төлж чадаагүй зүйлс, эзлэх хувь.....	22
Зураг 18. Ахмадуудын эрүүл мэндийн ерөнхий үнэлгээ, өөрсдөө үнэлсэн, эзлэх хувь.....	23
Зураг 19. Орлогын түвшин одоогоос 3 жилийн өмнөх үетэй харьцуулахад ямар болсон бэ?.....	23
Зураг 20. Ирээдүйн орлогын талаар (ирэх 3 жилд) хүлээлтийн түвшин.....	24
Зураг 21. Өөрийн санхүүгийн байдлаа үнэлсэн хувь.....	24
Зураг 22. Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны тэтгэвэр авагчдын ядуурах эрсдэл, гишүүн орноор.....	29
Зураг 23. Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны агрегат орлуулалтын харьцаа, гишүүн орноор.....	29
Зураг 24. Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны 65-аас дээш насны ахмадуудын орлогын тэгш бус байдал, гишүүн орноор.....	30
Зураг 25. Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны материал болон нийгмийн ноцтой гачигдал, 65-аас дээш насны ахмадуудын түвшин, гишүүн орноор.....	30

## ТАНИЛЦУУЛГА

Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүний тоо жилээс жилд өссөөр байна. Тухайлбал 2003 онд 17 966 ганц бие өндөр настай хүн байсан бол 2021 онд 44 148 болж 18 жилд 20 гаруй мянган хүнээр нэмэгджээ. Ганц биеэр амьдарч буй ахмадууд нийт ахмад настны 10.7 хувийг эзэлж байна.

**Зураг 1.** Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүний тоо, хүйсээр



Эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn)

Хүн амын дундаж наслалтын зөрүүнээс шалтгаалан эмэгтэй ахмад настнууд ганц биеэр өрх үүсгэн амьдарч байгаа нь нийтлэг үзэгдэл болжээ. Эдгээр ганц биеэр амьдарч байгаа ахмадууд Улаанбаатар хотод 17.9%, Орхон(8.3%), Хөвсгөл(5.5%), Архангай(5.4%), Говьсүмбэр(5.3%) аймагт хамгийн олон байна.

**Зураг 2.** Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүний тоо, аймгаар





## Сэдвийн судлагдсан байдал

Ахмад настан болон тэтгэврийн хүрэлцээний талаар дараах судалгаанууд Монгол Улсад хийгдсэн байна.

Үндэсний статистикийн хорооноос 2018 онд “Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа”-г хийж гүйцэтгэсэн байна. Уг судалгаанд ахмад настан тэргүүлэгчтэй өрхийн сарын орлогын дийлэнх хувийг тэтгэвэр, тэтгэмж эзэлдэг болохыг харуулсан байна.

Удирдлагын академийн Б.Нарантулга ахлагчтай баг 2019 онд “Өндөр насны тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал” судалгааг хийсэн байна. Энд тэтгэврийн хүрэлцээт байдлыг НДЕГ болон ҮСХ-ны статистик тоо мэдээлэлд тулгуурлан авч үзсэн.

Мөн ҮСХ 2020 онд хүн ам, орон сууцны тооллогын үр дүнд үндэслэсэн “Өндөр настан” сэдэвчилсэн судалгааг хийж гүйцэтгэсэн ба тус судалгаанд өндөр настны нийгэм, эдийн засгийн байдлыг авч үзсэн.

Философийн хүрээлэн 2022 онд “Ахмад настны социаль асуудал: Үр дагавар, төлөв хандлага” суурь судалгааг зохион байгуулсан. Судалгаанд ахмад настны 96.2 хувь нь тэтгэврээр амьжиргаагаа залгуулдаг гэсэн үр дүн гарсан байна.

Эдгээр судалгаа нь нийт ахмад настануудын захиргааны тоон мэдээлэлд суурилсан бол бид энэ удаагийн судалгааны үр дүнгээр ганц биеэр өрх үүсгэн амьдардаг ахмад настны тэтгэвэр тэтгэмжийн хүрэлцээ, зарцуулалтыг судлахыг зорьлоо.

## Зорилго

Энэ судалгааны зорилго нь ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй ахмад настны тэтгэврийн хүрэлцээ, зарцуулалтыг тодруулахад оршино. Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Ганц биеэр өрх үүсгэн амьдардаг ахмад настны тоон мэдээлэлтэй болох;
- Ахмад настны тэтгэврийн хэмжээг тодорхойлох;
- Өрхийн нийт орлогод тэтгэврийн эзлэх хувийг тодорхойлох;
- Тэтгэврийн зарцуулалт, зориулалтыг тодорхойлох;
- Тэтгэврийн хүрэлцээг тодорхойлох;
- Улмаар бодлого боловсруулагчдад зөвлөмж хүргэх.

## Түүврийн зохиомж

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй эрэгтэй 60, эмэгтэй 55-аас дээш насны 44148 ахмад настны тоо, мэдээлэл зорилтот бүлгийн хүн амын жагсаалт тул түүврийн хүрээ болгон ашигласан. Энгийн санамсаргүй түүврийн аргаар буюу дараах томъёогоор бодсон.

$$X = \frac{Z_{a/2}^2 p(1-p)}{MoE^2} \quad n_i = \frac{N_i * X}{X + N_i - 1}$$

$$\begin{aligned} a &= 5\% \\ Z_{a/2} &= 1.96 \\ p &= 0.5 \end{aligned}$$

Түүврийн хэмжээ: 95 хувийн ач холбогдлын түвшинд 5 хувийн алдааны хязгаартай байдлаар тооцоолж 401 ахмад настан түүвэрт хамрагдсан.

### Хүснэгт 1. Түүврийн хэмжээ

		Насны бүлэг			Нийт
		55-64 нас	65-74 нас	75-аас дээш	
Эрэгтэй	Хот	14	15	8	38
	Хөдөө	21	22	18	61
Эмэгтэй	Хот	49	34	20	104
	Хөдөө	77	67	54	198
Бүгд		161	139	100	401

Түүврийн хуваарилалтыг ахмад настны нас, хүйс, байршлыг харгалзан пропорциональ хийсэн.

### **Мэдээлэл цуглуулалт**

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг тоон судалгааны аргаар буюу утсан холбоогоор 2022 оны 12 дугаар сард зохион байгуулсан. Холболт хийхэд гурван ахмад тутмын нэг ахмад настантай л амжилттай холбогдож мэдээлэл цуглуулж байсан. Тухайн холболт хийх оролдлого амжилтгүй (дугаар ашиглалтад байхгүй, тухайн хүн нас барсан, холбогдох боломжгүй, дугаар буруу) болсон тохиолдолд нөөц түүврээс сонгогдсон иргэний нас, хүйс, байршлын хувьд ойролцоо ахмад настнаар орлуулан мэдээлэл цуглуулсан.

### **Судалгааны үндсэн асуултууд**

Үндэсний статистикийн хорооны мэдээллийн санд бүртгэлтэй ганц биеэр өрх үүсгэн амьдарч байгаа ахмад настны жагсаалтаас ахмад настны хаяг болон холбоо барих утасны дугаарыг авч түүвэрт хамруулсан тул бид тоон судалгааны асуулгын хуудсаар дараах мэдээллийг цуглуулсан.

- Ахмад настны амьдарч буй сууцны хэлбэр, өмчлөл;
- Тэтгэврийн хэмжээ;
- Тэтгэврийн зээлтэй эсэх;
- Тэтгэврийн хүрэлцээ;
- Ахмад настуудын эрүүл мэндийн байдал;
- Ирээдүйн тэтгэврийн хүлээлт;
- Ахмадуудын тэтгэврийн талаарх санал хүсэлт.

## СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд хамрагдсан ахмад настнуудыг насны бүлгээр харвал 161 (40.1%) нь 55 – 64 насны, 139 (34.7%) нь 65 - 74, 101 (25.2%) нь 75-аас дээш настай байна.

**Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан ахмад настнууд, хүйс, насны бүлгээр**

		Насны бүлэг			Бүгд
		55-64 нас	65-74 нас	75-аас дээш	
Хүйс	Эрэгтэй	35	37	26	98
	Эмэгтэй	126	102	75	303
Нийт		161	139	101	401


Хүйсээр харвал 24.4% нь эрэгтэй, 75.6% нь эмэгтэйчүүд байсан.

**Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан ахмад настнууд, байршил, насны бүлгээр**

		Насны бүлэг			Бүгд
		55-64 нас	65-74 нас	75-аас дээш	
Байршил	Хот	63	49	28	140
	Хөдөө	98	90	73	261
Нийт		161	139	101	401

Байршлын хувьд 34.9% нь Улаанбаатар хотод, 65.1% нь орон нутагт амьдарч байна. Судалгаанд хөдөө амьдарч буй 55-64 насны эмэгтэйчүүд түлхүү хамрагдсан.

**Зураг 3. Ахмад настны амьдарч буй сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр**



Судалгаанд хамрагдсан ахмад настнуудын 48% нь гэрт, 31.7% нь орон сууцанд, 16.3% нь байшинд, 3% нь хаус, 1% нь нийтийн байранд тус тус амьдарч байна. Сууцны өмчлөлийн хувьд 77.2% нь өөрийн сууцанд, 20.8% нь бусдын буюу хүүхэд, хамаатан садны сууцанд, 2% нь түрээсийн сууцанд амьдарч байсан. Харин гэрт амьдардаг ахмад настнуудын 89.1% нь өөрийнхөө гэрт, 9.9% нь бусдын, 1% нь түрээсийн гэрт амьдарч байна.

## СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

### *Тэтгэврийн хэмжээ ба дундаж орлого*

Судалгаанд хамрагдсан ганц бие ахмад настнуудын дундаж тэтгэвэр 544,1 мянган төгрөг байна. Улаанбаатар хотод амьдарч буй ахмадуудын дундаж тэтгэвэр 560.7 мянга, хөдөө орон нутагт амьдарч буй ахмадуудын дундаж тэтгэвэр 535.2 мянган төгрөг байгаа бол эрэгтэйчүүдийн дундаж тэтгэвэр 568.8 мянга, эмэгтэйчүүдийнх 536.1 мянган төгрөг байна.

Нийгмийн даатгалын сангийн бүрэн тэтгэврийн доод хэмжээ болох 500 мянган төгрөгөөр тэтгэвэр авдаг ахмад настнууд нийт судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь буюу 65.3% байна. Энэ үзүүлэлт Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл -2022<sup>2</sup> үзүүлэлттэй ойролцоо байсан.

**Зураг 4.** Судалгаанд хамрагдсан ганц бие ахмад настнуудын дундаж тэтгэврийн хэмжээ, боловсролын түвшингээр




Боловсролын түвшин өндөр байх тусам дундаж тэтгэврийн хэмжээ их байгаа дүр зураг ажиглагдсан.

Судалгаанд хамрагдсан ахмадуудын 20% нь тэтгэврээс гадна нэмэлт орлого олдог гэсэн бөгөөд орлогын бүтцийг зураг 5-д харууллаа.

<sup>2</sup> 2022 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг ахмад настны эзлэх хувь 67.8 хувь байсан.


**Зураг 5. Ганц бие ахмад настны орлогын бүтэц, эзлэх хувиар**



Ганц бие ахмад настны нийт орлогын 88.1%-ийг тэтгэвэр дангаараа бүрдүүлдэг бөгөөд 6.6%-ийг цалин, хөлсний орлого, 2.3% мал аж ахуйгаас, 1.1% үр хүүхдүүдээс авдаг мөнгө бүрдүүлдэг бол 0.8% -ийг халамж, 1.1% бусад орлого буюу түрээс, түр ажил хийж олсон орлого эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан ахмад настнуудын нийт орлого нь дунджаар 617.4 мянган төгрөг, хөдөлмөр эрхэлдэг<sup>3</sup> ахмадуудын дундаж цалин хөлс 604.4 мянган төгрөг байна.

**Зураг 6. Судалгаанд хамрагдсан ганц бие ахмад настны орлогын сэтгэл ханамж**



<sup>3</sup> Судалгаанд хамрагдсан нийт ахмадуудын 6.7 хувь нь

Ахмад настнуудаас орлогын сэтгэл ханамжийг 1-10 хүртэл оноогоор үнэлүүлсэн. Судалгаанд хамрагдсан ахмад настны сэтгэл ханамж дунджаар 3.7 буюу орлогодоо сэтгэл ханамжгүй гэсэн үр дүн гарсан. Харин сэтгэл ханамжийн түвшин эрэгтэйчүүд 4.1, эмэгтэйчүүд 3.7 гарсан.

### **Тэтгэврийн зарцуулалт**

Тэтгэврийн орлогоор хамгийн эхэнд юу худалдан авдаг, ямар төлбөр төлдөг вэ? гэсэн асуултад


1. Хоол хүнс
2. Эм, тариа
3. Цахилгаан болон усны төлбөр
4. Дулаан, түлшний төлбөр
5. Тээвэр, унааны мөнгө төлдөг гэж хариулсан.

Ихэнх ахмадууд хоол хүнс болон эм тариандаа л хүргэдэг гэсэн. Зарим ахмадууд хүнсээ ч авч хүрэхгүй байх тохиолдол байдаг гэж хариулсан.

Ахмадуудаас амралт, рашаан, сувилалд өөрийн мөнгөөр үйлчлүүлж чаддаг эсэхийг тодруулахад 81.8% нь үгүй гэж хариулсан.

Тэтгэврийн орлогоор амьжиргаагаа залгуулахад ямар байгаа талаар асуухад 64.1% нь хэцүү байдаг гэсэн ба 18% нь боломжийн гэж хариулсан.


#### **Зураг 7. Тэтгэврийн орлогоор амьдрах боломж, дүнд эзлэх хувиар**



Дээрх асуултад маш хэцүү болон хүндрэлтэй гэж хариулсан ахмадуудаас хүрэлцдэггүй хэсгээ нөхөхийн тулд хэнээс тусламж авдаг талаар лавлахад ах дүү, хүүхдүүдээс тусламж авдаг гэж 56.1% нь хариуллаа.


Судалгаанд хамрагдсан нийт ахмад настны 95.8% нь хүүхэдтэй гэсэн ба тэдний 59.4% нь хүүхдүүдээсээ тусламж авдаг байна.

**Зураг 8. Үр хүүхэд болон ач зээдээ санхүүгийн тусламж үзүүлдэг хувь**



Харин та өөрийн ач зээ, үр хүүхэддээ санхүүгийн тусламж үзүүлдэг үү? гэсэн асуултад 52.1% нь ямар нэг байдлаар тусалдаг гэсэн бол 47.9% нь чаддаггүй гэсэн.


**Зураг 9. Тэтгэврийн орлогоор амьжиргаагаа залгуулахад хүрэлцэхгүй үед авсан хариу арга хэмжээ, эзлэх хувиар**



Сүүлийн нэг жилд хэрэглээний төлбөрөө төлж чадахгүй тохиолдол гарсан уу? гэсэн асуултад 33.2 хувь нь үгүй гэсэн. Хариултыг хот, хөдөөгөөр доорх зурагт оруулав. Хотод амьдарч буй ганц бие ахмадууд хэрэглээний төлбөр (цахилгаан, ус, байрны ашиглалт) -өө төлж чадаагүй нь их байгаа ба ялангуяа 2 ба түүнээс дээш удаа төлж чадаагүй байна.



**Зураг 10.** Сүүлийн нэг жилд хэрэглээний төлбөрөө төлж чадахгүй байх тохиолдол гарсан эсэх, хариултын эзлэх хувь, байршлаар



Бид ахмадуудыг санхүүгийн хувьд гэнэтийн зардал гаргахад бэлэн байдлыг тандах зорилгоор 1 сая төгрөгийн зардал гарахад төлж чадах уу? гэж асуухад 80.55 хувь нь төлж чадахгүй буюу бэлэн биш гэж байна. Харин төлж чадна гэсэн ахмадуудын тэтгэвэр дундаж тэтгэврээс өндөр байгаа ба 621.2 мянган төгрөг байна.

**Хүснэгт 4.** Гэнэтийн зардалд бэлэн байдал, дундаж тэтгэврийн хэмжээгээр

	Та зээл авахгүйгээр гэнэтийн зардал (1 Сая төгрөг) гарвал төлж чадах уу?	Дундаж тэтгэвэр /мян.төг/
Тийм	19.45%	621.24
Үгүй	80.55%	525.46

### Тэтгэврийн хүрэлцээ

Европын холбооны Нийгмийн хамгааллын хороо(SPC)-оос 2012 оноос эхлэн 3 жил тутам гишүүн орнуудын тэтгэврийн тогтолцоог (өндөр настнуудын одоогийн болон ирээдүйд орлогын хүрэлцээг) харьцуулах зорилгоор Тэтгэврийн хүрэлцээний тайлан (PAR) гаргадаг<sup>4</sup>. Энэ тайланд (i) ядуурлаас хамгаалсан байдал (ii) орлогын баталгаа (iii) тэтгэвэр авах хугацаа гэсэн 3 хэмжигдэхүүнээр хүрэлцээг хэмждэг.

Эхний хэмжигдэхүүн нь тэтгэврийн хүрэлцээг 65 ба түүнээс дээш насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн материаллаг болон нийгмийн хомсдол зэрэг хүчин зүйлсийг харгалзан өндөр насны ядуурлаас урьдчилан сэргийлэх, бууруулах чадварыг харуулдаг.

<sup>4</sup> Pension adequacy report 2021 Current and future income adequacy in old age in the EU

Хоёрдугаар үзүүлэлт нь тэтгэврийн хүрэлцээг тэтгэвэрт гарахаас өмнө олсон орлогыг нөхөх, улмаар ажлаас тэтгэвэрт гарахад үзүүлэх санхүүгийн нөлөөллийг хязгаарлаж, улмаар тэтгэвэрт гарахын өмнөх амьдралын түвшнийг хир хэмжээнд барих боломжтойг үнэлдэг. Үүнийг тэтгэвэрт гарахын өмнөх болон дараах ижил хүмүүсийн орлогыг харьцуулах, эсвэл өндөр настай/тэтгэвэрт гарсан хүн амын орлогыг залуу/хөдөлмөр эрхэлж буй хүн амтай харьцуулах замаар хэмжиж болно.

Гуравдах үзүүлэлт нь хүн амын дундаж наслалтаас хамаарч тэтгэвэр авах хугацаандаа хүрэлцэхүйц тэтгэвэртэй байхыг авч үздэг. Тэтгэвэрт гарах хугацаанд хүмүүсийн хүрэлцээт байдал өөрчлөгддөг бөгөөд энд орлогын түвшин, өрхийн бүтэц, эрүүл мэндийн байдал, асаргаа сувилгааны хэрэгцээнд гарсан өөрчлөлт нөлөөлдөг учраас улс орнууд бодлогын түвшинд авч үздэг.

Эхний хэмжигдэхүүн Ядуурах эрсдэл (At-risk of poverty) тооцохдоо ядуурлын шугамнаас доогуур орлоготой тэтгэвэр авагчдын эзлэх хувиар гаргадаг. Европын холбооны Орлого болон амьдрах нөхцлүүдийн статистик (EU-SILC) судалгаанд татварын дараах медиан орлогын 60 хувиар тооцдог.

Дараагийн хэмжигдэхүүн нь Агрегат орлуулах харьцаа (Aggregate replacement ratio)-г тооцохдоо 65-74 насны хүмүүсийн тэтгэврийг идэвхтэй ахмад настнуудын (50-59 нас) орлоготой харьцуулна.

Гурав дах хэмжүүр нь орлогын тэгш бус байдал (Income inequality)-ийг 65-аас дээш насны хамгийн баян 20 хувийг хамгийн бага орлоготой 20 хувьд харьцуулж тооцдог.

Дөрөв дэх хэмжигдэхүүн нь материаллаг болон нийгмийн гачигдал (Material and social deprivation) ба 65-аас дээш насны ахмадууд 13<sup>5</sup> зүйлээс 5-ийг нь авч чадахгүй байгаа хүмүүсийн эзлэх хувиар тооцдог.

Дээрх үзүүлэлтүүдийг Монгол Улсын ганц биеэр өрх үүсгэн амьдардаг судалгаанд хамрагдсан ахмад настнуудын хувьд тооцож үзсэн.

#### **Хүснэгт 5.** Монгол Улсын хувьд тэтгэврийн хүрэлцээг тооцсон үр дүн

	Ядуурах эрсдэл (хувиар)	Агрегат орлуулах харьцаа	Орлогын тэгш бус байдал	Материаллаг болон нийгмийн гачигдал (хувиар)
<b>Нийт</b>	72.8	43.2 <sup>6</sup>	14.8	38.2
<b>Эрэгтэй</b>	62.2	43.2	7.2	35.7
<b>Эмэгтэй</b>	76.2	43.2	18.4	38.9


<sup>5</sup> Хавсралтаар 13 зүйлийг жагсаалтыг оруулсан.

<sup>6</sup> Медиан цалингаар тооцсон

## Ядуурах эрсдэл


Бид ядуурах эрсдэл тооцохдоо татварын дараах<sup>7</sup> медиан цалин<sup>8</sup>-ийн 60 хувиар авсан. Ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй ахмад настны ядуурах эрсдэлийн түвшин 72.8 хувь буюу маш өндөр гарсан. Энэ үзүүлэлт нь бараг 4 хүн тутмын 3 нь ядуу байна гэсэн үг. Ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд илүү өндөр ядуурах эрсдэлтэй байна.

**Зураг 11.** Ядуурах эрсдэлийн түвшин, насны бүлэг, байршлаар



Харин 75-аас дээш настай ахмадуудын хувьд ядуурах эрсдэл маш өндөр буюу 80.2 хувь, мөн хөдөөд илүү их ядуурах эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл хөдөө амьдарч байгаа болон 75-аас дээш насны ахмад настай 5 хүн тутмын 4 нь ядуурах эрсдэлтэй байгааг харуулж байна.

**Зураг 12.** Ядуурах эрсдэлийн түвшин, сууцны төрөлөөр



<sup>7</sup> Дунджаар 21.7 хувиар тооцсон.

<sup>8</sup> 2022 оны 3 дугаар улирлын медиан цалин 1,157.427 төгрөг

Сууцны төрлөөр ядуурах эрсдэлийн түвшинг харвал гэрт амьдарч буй ахмад настнууд илүү өндөр, харин орон сууц болон байшинд амьдардаг ахмадууд бусдаас арай бага эрсдэлтэй байна.


### Тэтгэврийн зээл

Судалгаанд хамрагдсан ахмадуудын 35.9 хувь нь одоо тэтгэврийн зээлтэй гэсэн ба зээлтэй ахмадууд зээлээ төлөөд үлдсэн мөнгө нь дунджаар 106.8 мянган төгрөг байна. Харамсалтай нь зээл авсан ахмадуудын 31.3 хувь нь зээлээ төлсний дараа ямар ч орлогогүй үлддэг. Энэ нь “Хүн амын амьжиргааны доод түвшин” 2022 он<sup>9</sup>-оос ч бага мөнгөтэй үлдэж байгааг харууллаа.

Тэтгэврийн зээлтэй ахмадууд бараг бүгд ядуу болж байна. Тэтгэврийн зээлгүй ахмадууд ч мөн ядуурах эрсдэл өндөр байгаа нь зээл авахаасаа ч өмнө ядууралд өртөх эрсдэлтэй байгааг харуулж байна.

Монгол банкны 2022 оны 12 дугаар сарын “Мөнгө, санхүүгийн статистик”-аар тэтгэврийн зээлийн үлдэгдэл 517.4 тэрбум төгрөг байна.

**Зураг 13.** Ядуурах эрсдэлийн түвшин, тэтгэврийн зээл авсан аваагүй ахмадуудаар



### Агрегат орлуулах харьцаа

Энэ тооцооллыг хийхэд 65-74 насны тэтгэвэр авагчдын тэтгэвэр болон 50-59 насны иргэдийн орлогын мэдээлэл хэрэгтэй. Бид үүнийг орлуулан тэтгэвэр авч байгаа иргэдийн дундаж тэтгэврийг<sup>10</sup> дундаж цалинд<sup>11</sup> харьцуулсан. Өөр нэг арга нь медиан тэтгэвэр<sup>12</sup>-ийн хэмжээг медиан цалинд харьцуулж болно. Тэтгэвэр авч байгаа иргэд ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн орлогын хэдэн хувийг авч байгааг харуулдаг. Өөрөөр хэлбэл дундаж цалингаар тооцвол тэтгэвэр авч байгаа ахмад настнууд ажил хийж байгаа иргэдийн 44.2 хувьтай тэнцэхүйц орлоготой байна.

Ганц бие ахмадуудын агрегат орлуулалтын харьцаа 43.2 хувь гарсан нь Дани, Словени, Латви зэрэг Улстай ойролцоо байгааг харуулж байна. Хавсралтаар Европын холбооны гишүүн орнуудын хувь, хэмжээг оруулав.

<sup>9</sup> Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн тушаалаар Улаанбаатар хотод 277800, баруун бүс 238800, хангайн бүс 240400, төвийн бүс 239200, зүүн бүс 236400 тус тус байна.


<sup>10</sup> 544.1 мянган төгрөг буюу судалгааны үр дүн

<sup>11</sup> 2022 оны 3 дугаар улирлын дундаж цалин 1573.1 мянган төгрөг (татварын дараах дүн 1231.7)

Медиан тэтгэврийн хэмжээ эрэгтэй, эмэгтэй ямар нэг ялгаагүй бүгд 500 мянган төгрөг буюу бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр байгаа тул агрегат орлуулах харьцаа 43.2 хувь гарсан.

Дундаж болон медиан цалингаар тооцон үзэхэд маш бага ялгаа гарсан.

**Зураг 14.** Агрегат орлуулах харьцаа, дундаж болон медиан цалингаар



#### Орлогын тэгш бус байдал

Орлогын тэгш бус байдлыг 65-аас дээш насны ахмад настнуудаар биш судалгаанд хамрагдсан бүх ахмадын хувьд тооцсон. Учир нь энэ судалгааны түүвэр бага мөн ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй ахмад настнуудын хувьд л авч үзсэн.


Хэмжигдэхүүн мөн л өндөр үзүүлэлт гарлаа. Энэ үзүүлэлт нь хамгийн өндөр орлоготой (нийт орлого нь хамгийн өндөр 20% нь) ахмадууд хамгийн бага орлого<sup>13</sup>-той (нийт орлого нь хамгийн бага орлоготой 20%) ахмадуудаас 14.8 дахин их орлоготой байгааг илтгэж байгаа юм. Ялангуяа эмэгтэй ахмадуудын орлогын ялгаа их байна.

Насны бүлэг тус бүрээр харьцуулан харахад шинээр тэтгэвэрт гарсан иргэдийн хувьд орлогын ялгаатай байдал илүү анзаарагдсан. Өөрөөр хэлбэл 55-64 насны тэтгэвэр авагчдын дунд зөрүү маш өндөр байгааг харуулж байна.

<sup>12</sup> 500 мянган төгрөг

<sup>13</sup> Тэтгэврийн зээл тооцсон дүн

**Зураг 15. Орлогын тэгш бус байдал, насны бүлэг, хүйсээр**



### Материаллаг болон нийгмийн гачигдал

Европын холбооны Орлого болон амьдрах нөхцлүүдийн статистик (EU-SILC) судалгаанд 13 зүйлээс 5-ийг нь худалдаж авч чадахгүй бол материаллаг болон нийгмийн гачигдалтай гэж үздэг. Мөн 13 зүйлээс 7-г нь авч чадахгүй бол материаллаг болон нийгмийн ноцтой гачигдал (Severe material and social deprivation) гэж үздэг.

Бид энэ судалгаанд материаллаг болон нийгмийн гачигдлын тооцооллыг хийхийг оролдсон ба ингэхдээ 13 зүйлийг Монголд тохиромжтой гэж үзсэн дараах 8 зүйлээр асуусан.

Та сүүлийн нэг жилд санхүүгийн хүндрэлийн улмаас дараах зүйлсийг худалдаж авч чадаагүй тохиолдол гарсан уу?


1. Хүнс (мах, гурил, ногоо гэх мэт)
2. Эм, тариа
3. Хувцас
4. Цахилгаан, усны төлбөр
5. Дулаан, халаалтын төлбөр (байрны мөнгө, түлээ, нүүрсний мөнгө)
6. Холбооны зардал (Утасны төлбөр, нэгж)
7. Зээлийн төлбөр
8. Тээврийн зардал (Унаа, шатахууны мөнгө)

Ингээд эдгээр зүйлээс 4-ийг нь төлж чадаагүй гэсэн бол материаллаг болон нийгмийн ноцтой гачигдалтай гэж авч үзсэн.

Материаллаг болон нийгмийн ноцтой гачигдлийн түвшин 38.2% гарсан ба эмэгтэйчүүд арай өндөр хувьтай гарсан.

Насны хувьд 55-65 насны хүмүүс илүү их материаллаг болон нийгмийн ноцтой гачигдалтай гарсан. Харин байршлын хувьд ойролцоо буюу хотод 38.6%, хөдөөгийн ганц бие өрх үүсгэн амьдардаг ахмадуудын материаллаг болон нийгмийн ноцтой гачигдал 37.9%-тай байсан.

**Зураг 16. Материаллаг болон нийгмийн ноцтой гачигдал, хүйс, насны бүлгээр**




Судалгаанд хамрагдсан ганц бие ахмадуудын хувьд эм, тариа, хүнс, хувцас худалдан авч чадаагүй тохиолдол маш их гарчээ. Харин зээлийн төлбөр болон тээврийн зардал (унааны мөнгө, шатахууны төлбөр)-аа төлж чадахгүй байх хувь харьцангуй бага байна.

**Зураг 17. Сүүлийн нэг жилд санхүүгийн хүндрэлийн улмаас худалдаж авч чадаагүй/төлж чадаагүй зүйлс, эзлэх хувь**



Судалгаанд хамрагдсан ахмад настнууд өөрсдийн эрүүл мэндээ үнэлэхдээ тааруу гэж 41.7% нь үзсэн бол 32.9% нь боломжийн байгаа гэсэн бол 21.7% нь нилээн хүнд буюу тогтмол эм, тариа хэрэглэдэг тухайгаа хэлж байсан. Харин 3.8% нь буюу маш цөөн ахмадууд өөрсдийгөө эрүүл гэсэн.

**Зураг 18.** Ахмадуудын эрүүл мэндийн ерөнхий үнэлгээ, өөрсдөө үнэлсэн, эзлэх хувь



### Ахмадуудын санал, хүсэлт


Ахмадуудаас тэтгэвэр болон орлогын талаар хэд хэдэн нээлттэй асуултууд асуусан ба эхний асуулт нь хүрэлцэхүйц тэтгэврийн хэмжээ хэд байвал зохимжтой талаар тодруулсан.

Тэдний бодлоор тэтгэвэр дунджаар 926 мянган төгрөг байвал амьжиргаагаа залгуулж хүрэлцэнэ гэсэн ба 5.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Хотод амьдарч буй ахмадууд тэтгэврийг дунджаар 973.3 мянган төгрөг байх гэсэн бол хөдөөгийн ахмадууд 900 мянган төгрөг байх нь зүйтэй гэсэн.

Харин ядуурах эрсдэл өндөртэй байгаа ахмадуудын хүсч буй дундаж тэтгэвэр 893.9 мянган төгрөг байгаа бол эрсдэлгүй ахмадуудын хувьд 1006.9 мянган төгрөг байсан.

Орлогын түвшин 3 жилийн өмнөх үетэй харьцуулахад 60.1% нь буурсан гэсэн бол 27.2% нь хэвэндээ, 11.5% нь бага зэрэг өссөн гэсэн бол 1.3% нь мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн.


**Зураг 19.** Орлогын түвшин одоогоос 3 жилийн өмнөх үетэй харьцуулахад ямар болсон бэ?





Харин ирээдүйд буюу ирэх 3 жилд орлогын талаарх хүлээлтийг асуухад 27.2% нь мэдэхгүй гэсэн бол 34.4% нь буурна гэсэн бодолтой байна. Багахан буюу 14% нь орлого бага зэрэг нэмэгдэнэ гэсэн эерэг хүлээлттэй байсан.


**Зураг 20.** Ирээдүйн орлогын талаар (ирэх 3 жилд) хүлээлтийн түвшин



Ганц биеэр өрх үүсгэн амьдардаг ахмад настнууд өөрсдийн санхүүгийн байдлаа үнэлэхдээ дунджаас бага гэж дийлэнх нь (70.6%) үзэж байгаа бол 22% нь дундаж, харин 7% нь мэдэхгүй, 0.5% нь дунджаас дээгүүр орлоготой гэлээ.

Эндээс дүгнэвэл тэд өөрсдийн орлого, тэтгэвэр, санхүүгийн байдалдаа сэтгэл ханамжгүй байгааг илтгэж байна.

**Зураг 21.** Өөрийн санхүүгийн байдлаа үнэлсэн хувь



Ганц биеэр өрх үүсгэн амьдардаг ахмад настнуудаас тэтгэвэр болон дэмжлэгийн талаар санал асуухад дараах хариултуудыг хамгийн ихээр өгсөн.

<i>Ирсэн санал</i>	
1	Тэтгэвэр нэмэх;
2	Хүнсний үнийн өсөлтөнд хязгаарлалт тавих;
3	Эмийн үнийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэх, хөнгөлөлттэй эмийн жагсаалтад зарим эмийг нэмэх;
4	Ажилласан жилтэй уялдуулан тэтгэвэр тогтоодог байх;
5	Эмийн үнийн өсөлтөд зохицуулалт хийх;
6	Хөдөлмөр эрхлүүлэх боломжоор хангах, ЖДҮ, хөнгөлөлттэй зээлд хамруулах;
7	Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлтөд хамрагдах илүү квот нэмэх;
8	Сэтгэлзүйч болон нийгмийн ажилтнууд ХБИ ахмадуудтай тулж ажиллах, нийгмийн харилцаанд оруулах талаас анхаарах;
9	Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, эрт илрүүлэгт хамруулах, дараалалгүй үйлчлүүлэх боломжтой болох;
10	“Насны хишиг <sup>14</sup> ”-ийг тэтгэвэрт гарж байгаа наснаас эхлэн олгох, мөнгөн дүнг нэмэгдүүлэх;
11	Ахмадуудад асаргаа, хоол унд, тусламж, үйлчилгээ үзүүлдэг ахмадын төв барих;
12	Ахмадын рашаан, сувилал, эмчилгээг жилд нэг удаа үнэгүй болгох;
13	Ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй ахмадуудыг баг, хорооны засаг дарга, нийгмийн ажилтнууд Ахмадын баяраар хүлээн авдаг болох;

<sup>14</sup> МУ-ын ЗГ-ын 31-р тогтоолоор Насны хишиг олгох журам батлагдсан.

## ДҮГНЭЛТ

Ганц биеэр өрх үүсгэн амьдардаг ахмад настнуудын тэтгэврийн хүрэлцээ, зарцуулалтыг тодруулахаар 401 өндөр настнаас утсаар мэдээлэл цуглуулан, ЕХ-ны аргачлалаар судалгааны асуултуудыг боловсрууллаа. Ингээд гарсан үр дүнгүүдээс дараах дүгнэлтүүдийг хийж байна.

Ганц биеэр өрх үүсгэн амьдарч байгаа ахмадуудын дийлэнх (78.6 хувийг) эмэгтэйчүүд эзэлж байна. Энд эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах нас эрэгтэйчүүдийнхээс 5 насаар бага байгаа болон дундаж насны зөрүү нөлөөлж байна.

Судалгаанд хамрагдсан ахмад настнуудын дундаж тэтгэвэр 544,1 мянган төгрөг ба энэ нь нийт орлогын 88.1% буюу тэд тэтгэврээс өөр орлогогүй байна гэж хэлж болохоор байна. Тэгэхээр амьжиргааны түвшин нь тэтгэврийн хэмжээнээс шууд хамааралтай байна.

Харин тэтгэврийн зарцуулалтын хувьд хоол, хүнс, эм тариандаа л хүргэдэг гэж дийлэнх ахмадууд хэлж байсан ба сарын тэтгэврээр амьжиргаагаа залгуулахад хүндрэлтэй гэж 64.1% нь хариулсан. Улмаар тэд орлогодоо сэтгэл ханамжгүй байна.

Сарын тэтгэврээрээ амьжиргаагаа залгуулахад хүрэлцэхгүй тохиолдолд тэдний 56.1% нь ах, дүү, хүүхдүүдээсээ тусламж хүсдэг гэж хариулсан нь санхүүгийн хүндрэл тэдний үр хүүхэд рүү орж даамжирдаг байж болзошгүйг харуулж байна. Мөн 5 ахмад тутмын 4 нь санхүүгийн хувьд гэнэтийн зардалд бэлтгэлгүй байсныг судалгаа харуулсан.

Тэтгэвэр бол даатгуулагчийг өндөр наслахад нь нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгож буй мөнгөн хөрөнгийг хэлнэ<sup>15</sup>. Энэ мөнгөө урьдчилж зээлээд сард дунджаар 106.8 мянган төгрөг<sup>16</sup> буюу амьжиргааны баталгаажих доод түвшнээс ч доогуур мөнгөөр амьжиргаагаа залгуулж байна.

Тэтгэврийн хүрэлцээг Европын холбооны улсуудын ашигладаг 4 аргаар тооцохыг оролдсон ба эхний үзүүлэлт болох ядуурах эрсдэлийн түвшин 72.8 хувь гарсан нь маш өндөр байгааг харуулсан. Ахмад настнуудыг ядуурах эрсдэлд оруулж байгаа нэг хүчин зүйл нь “Тэтгэврийн зээл” гэж хэлж болохоор байна. Учир нь тэтгэврийн зээл авсан ахмадуудын 93.1 хувь нь ядуурах эрсэлтэй байгаа бол тэтгэврийн зээлгүй ахмадуудын ядуурах эрсдэл 61.5 хувь байсан. Энэ үзүүлэлт 75-аас дээш насны ахмадууд (80.2%) илүү өндөр байгаа ба хөдөө орон нутгийн ахмадууд (79.3%) ч мөн хүнд байна.

Ганц бие ахмадуудын агрегат орлуулалтын харьцаа 43.2 хувь байгаа нь тэтгэврийн хэмжээ одоо ажил хийж байгаа иргэдийн медиан цалингийн 43.2 хувьтай тэнцэж байгааг илэрхийлж байгаа ба Дани, Словени, Латви улстай ойролцоо байна.

Орлогын тэгш бус байдал судалгаанд хамрагдсан ахмад настнуудын хувьд маш өндөр буюу хамгийн өндөр орлоготой ахмадууд хамгийн бага орлоготой ахмадуудаас 14.8 дахин их байгаа үр дүн гарсан. Ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд

<sup>15</sup> Нийгмийн даатгалын ерөнхий хууль

<sup>16</sup> Судалгааны үр дүн

энэ үзүүлэлт нь 18.4 гарсан нь хэт их ялгаатай байгааг харууллаа. Энд мөн л тэтгэврийн зээл нөлөөлж байна.

Дөрөв дэх үзүүлэлт болох материаллаг болон нийгмийн ноцтой гачигдалтай байгаа ахмадуудын 38.2% байгаа нь мөн л сайнгүй үр дүнг харуулсан.

Ахмадуудын хувьд эм, тариагаа худалдаж авч чадахгүй байх хувь хамгийн өндөр буюу 72.6% байсан мөн тэд өөрсдийн эрүүл мэндээ хүнд гэж 41.7% нь хэлснийг авч үзвэл ахмадуудын хувьд эрүүл мэндийн асуудал их байгааг илтгэж байна.

Ингээд ахмадуудаас хамгийн их ирсэн санал нь тэтгэвэр нэмэх, Хүнсний барааны үнийн өсөлтөд хязгаарлалт тавих, Эмийн үнийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэх, хөнгөлөлттэй эмний жагсаалтад зарим эмийг нэмэх, Ажилласан жилтэй уялдуулан тэтгэвэр тогтоох, Хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, ЖДҮ, хөнгөлөлттэй зээлд хамрагдах зэрэг байлаа.

## ЗӨВЛӨМЖ

Тэтгэврээр бараа бүтээгдэхүүн худалдан авах чадвар жил ирэх тусам буурч байгаа тул<sup>17</sup> тэтгэврийг жил бүр хэрэглээний үнийн өсөлтөөр индексжүүлдэг байхыг зөвлөж байна.

Ахмадуудын зүгээс тэтгэвэр тогтоохдоо ажилласан жилтэй уялдуулдаг байх талаар маш их санал ирсэн тул энэ хүсэлтийг хүлээн авахыг зөвлөж байна. Учир нь 30 жил шимтгэл төлсөн даатгуулагч ч гэсэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэврээ тогтоолгосон тохиолдол байна.

Дараагийн санал болгож буй зөвлөмж нь тэтгэврийн даатгалын санд шууд нөлөөлөхгүй ч ахмад настнуудад хэрэгцээтэй байгаа эмийн үнийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэх эсвэл хоол, хүнсний дэмжлэг үзүүлэх замаар тусламж үзүүлэхийг санал болгож байна.

Цаашид ахмадуудыг тэтгэвэр барьцаалан зээл гаргахгүй байхад онцгойлон анхаарахыг зөвлөж байна. Учир нь зээл авсан ахмад настнуудын ядуурах эрсдэлийн түвшин хамгийн их буюу зээл аваад л шууд ядууралд өртөж байна.

Ахмад настнуудын хамгийн ихээр зээл авдаг үндэсний баяр болох “Цагаан сар”-ын өмнө “Насны хишиг”-ийн мөнгөн дүнг нэмэгдүүлбэл зээл авах тохиолдол буурч болох юм.

Хэрэв тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх бол ажилласан жилтэй уялдуулж, 75-аас дээш насны хөдөө орон нутагт амьдарч буй ахмадуудын тэтгэврийг хамгийн эхэнд нэмэхийг зөвлөж байна.

Мөн судалгаанд хамрагдсан ахмадуудын дийлэнх нь гэрт амьдарч байсан тул түлээ, нүүрсний хөнгөлөлтийг ч Ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй ахмадууд руу чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.


Энэ судалгаа нь нэгэнт тэтгэвэр тогтоолгочихсон ахмадуудын тухайд авч үзэж байгаа тул нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ эсвэл тэтгэврийн насны талаар зөвлөмж өгөх нь зохисгүй тул эдгээр параметруудийн өөрчлөлтийг хийхийг зөвлөхгүй.

Европын холбооны зөвлөх Стивэн Яанссэн хэрэв ядуурах эрсдэлийн түвшинд байгаа ахмад настнуудаа бүгдийг ядуурлаас гаргахыг зорьж байгаа бол тэтгэврийн доод хэмжээг ажилласан жилтэй уялдуулж 543,0 мянган төгрөг болгохыг санал болгосон.


<sup>17</sup> 2023 оны 12 дугаар сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 129.2%, 2020=100%

## ХАВСРАЛТ


**Зураг 22.** Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны тэтгэвэр авагчдын ядуурах эрсдэл, гишүүн орноор




**Зураг 23.** Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны агрегат орлуулалтын харьцаа, гишүүн орноор



**Зураг 24.** Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны 65-аас дээш насны ахмадуудын орлогын тэгш бус байдал, гишүүн орноор



**Зураг 25.** Европын холбооны EU-SILC 2021 оны судалгааны материал болон нийгмийн ноцтой гачигдал, 65-аас дээш насны ахмадуудын түвшин, гишүүн орноор



## Материаллаг болон нийгмийн гачигдал тооцох 13 зүйл

1. Гэнэтийн зардалд бэлэн байх чадвар;
2. Жил бүр гэрээсээ хол 7 хоног амралтад явж чаддаг байх;
3. Ипотек, хэрэглээний төлбөр эсвэл худалдан авалтын төлбөрөө хугацаа хэтрүүлэхгүй байх;
4. Хоёр хоног тутамд мах, тахиа, загас эсвэл цагаан хоолтонтой тэнцэх хэмжээний хоол идэх боломжтой байх;
5. Гэр орноо хангалттай дулаан байлгах;
6. Хувийн хэрэгцээнд зориулагдсан машинтай байх;
7. Элэгдсэн тавилгыг солих боломжтой байх;
8. Интернет холболттой байх;
9. Хуучирсан хувцсыг шинэ хувцасаар солих;
10. Өөртөө таарсан хоёр хос гутал (улирал бүрт өмсөх гутал оруулаад)-тай байх;
11. Долоо хоног бүр өөртөө бага хэмжээний мөнгө зарцуулах чадвар;
12. Чөлөөт цагаа идэвхтэй өнгөрүүлэх боломжтой байх;
13. Сард ядаж нэг удаа найз нөхөд/гэр бүлийнхэнтэйгээ цуг ууж/идэх чадвартай байх.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа, Үндэсний статистикийн хороо, 2018 он
2. Өндөр насны тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал судалгаа, Б.Нарантулга, 2019 он
3. Өндөр настан сэдэвчилсэн судалгаа, ҮСХ, 2020 он
4. Ахмад настны социаль асуудал: Үр дагавар, төлөв хандлага, Философийн хүрээлэн, 2022 он
5. [www.1212.mn](http://www.1212.mn)
6. [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn)
7. [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)
8. <http://www.socieux.eu/>
9. Pension adequacy report, Current and future income adequacy in old age in the EU, 2021, Vol. 1
10. Pension adequacy report, Current and future income adequacy in old age in the EU, 2021, Vol. 2 Country profiles
11. Methodological guidelines 2021 operation v4 09.12.2020